



ХОВД АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 5/06

Ховд

Санал дэмжих тухай

Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлага бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар Тэргүүлэх аудитор Х.Болдбаатарын илтгэлийг хэлэлцээд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймаг дахь Төрийн аудитын газраас орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, хөтөлбөр арга хэмжээний зардлыг бууруулан шинээр эхлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, авлага барагдуулах, төлөвлөлтийг оновчтой болгох талаар өгсөн саналууд нь Засгийн газраас 2022 оны төсвийг батлахад баримталсан орон нутгийн төсвийн бие даасан байдлыг хангах, санхүү эдийн засгийн чадавх, нөөц боломжид тулгуурласан, тооцоо судалгаагаар батлагдсан, хэрэгжих боломжтой саналууд байгааг үндэслэн орон нутгийн 2022 оны төсвийн орлогыг 389.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх зардлыг 340.0 сая төгрөгөөр бууруулан төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

2.Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д ДААЛГАХ нь :

2.1.Газрын төлбөр, ус ашигласны болон түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрийн ногдуулалтыг тооцоо судалгаа, орон нутгийн нөөц боломжид үндэслэн төлөвлөх

2.2.Усны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад холбогдох төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах

2.3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан балансад бүртгэлтэй хуримтлагдсан насжилт өндөртэй авлагыг барагдуулах ажил зохион байгуулж авлага бууруулан, төсвийн орлогыг нэмэгдүүлэх.

3.Тэргүүлэх Аудитор /Х.Болдбаатар/-т ЗӨВЛӨХ нь:

3.1.Орон нутгийн 2022 оны төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар өгсөн саналын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ